



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/266

Улаанбаатар хот

┌ Шинэ мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа ┐  
эрхлэх энгийн зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.2 дугаар зүйлийн 2.2.1, 3.2 дугаар зүйлийн 3.2.1.1, 8.2 дугаар зүйлийн 8.2.6.14, Боловсролын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 20 дугаар зүйлийн 20.5, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.7, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны А/11 дүгээр тушаал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/127 дугаар тушаалаар байгуулагдсан магадлан шалгах ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Мэргэжлийн болон техникийн боловсролын шинэ мэргэжлээр сургалт эрхлэх энгийн зөвшөөрлийг хавсралтад дурдагдсан сургалтын байгууллагуудад олгосугай.

2. Мэргэжлийн болон техникийн боловсролын шинэ мэргэжлийн сургалтын орчин, хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, дадлагын баазыг бэхжүүлэх, багш, хүний нөөцийн ур чадварыг дээшлүүлэн сургалтын үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Мэргэжлийн болон техникийн боловсролын шинэ мэргэжлийн энгийн зөвшөөрлийг холбогдох хуулийн дагуу Зөвшөөрлийн цахим системд бүртгэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллахыг Мэргэжлийн болон техникийн боловсролын газар (А.Халиунаа), салбарын мэдээллийн системийн хөгжүүлэлт, мэргэжлийн бүртгэлийг системд шинэчлэхийг Цахим бодлого, статистик мэдээллийн газар (Т.Бат-Эрдэнэ), хэрэгжилтийг ханган ажиллахыг Боловсролын ерөнхий газар (Т.Ням-Очир)-т тус тус даалгасугай.

4. Мэргэжлийн болон техникийн боловсролын шинэ мэргэжлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэхэд Зөвшөөрлийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэх хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Төгсбаяр)-т даалгасугай.

САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

14241 0920

Боловсрол, шинжлэх ухааны сайдын  
2024 оны 05 дугаар сарын 31 өдрийн  
АБСГ тушаалын хавсралт

МЭРГЭЖЛИЙН БОЛОН ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛЫН ШИНЭ  
МЭРГЭЖЛЭЭР СУРГАЛТ ЭРХЛЭХ ЭНГИЙН ЗӨВШӨӨРӨЛ

Д/д	Сургалтын байгууллага	Ерөнхий чиглэл	Индекс	Мэргэжлийн чиглэл	Боловсролын түвшин	Хугацаа
1	Их засаг мэргэжлийн боловсролын сургууль	06.Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд	061206	Веб дизайн	Мэргэжлийн боловсрол	2027.07.01
2	Өвөрхангай аймаг дахь политехник коллеж	07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	072902	Уурхайн машин механизмын ашиглалт	Техникийн боловсрол	2027.07.01
3	Төв аймгийн Эрдэнэ суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	06.Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд	061101	Хэрэглээний программ	Мэргэжлийн боловсрол	2027.07.01
		08.Хөдөө аж ахуй, загасны аж ахуй, мал эмнэл зүй	084101	Мал, амьтны эмнэл зүй	Техникийн боловсрол, Мэргэжлийн боловсрол	2027.07.01
4	Техник технологийн политехник коллеж	10.Үйлчилгээ	101501	Аялал жуулчлалын үйлчилгээ	Мэргэжлийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071309-1	Цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ	Мэргэжлийн боловсрол	2027.07.01
5	Хэнтий аймаг дахь политехник коллеж	08.Хөдөө аж ахуй, загасны аж ахуй, мал эмнэл зүй	088803	Хосолсон фермийн аж ахуй	Мэргэжлийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071601-1	Авто кузов засвар, будаг	Мэргэжлийн боловсрол	2027.07.01
6	Аялал жуулчлалын ур чадвар мэргэжлийн боловсролын сургууль	04.Бизнес, удирдлага, эрх зүй	041501	Оффисын болон бичиг хэргийн ажил	Мэргэжлийн боловсрол (1 жил)	2027.07.01
7	Завхан аймгийн Тосонцэнгэл суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	10.Үйлчилгээ	101501	Аялал жуулчлалын үйлчилгээ	Мэргэжлийн боловсрол (1 жил)	2027.07.01
8	Этүгэн мэргэжлийн боловсролын сургууль	09.Эрүүл мэнд, нийгмийн хамгаалал	091502	Хөдөлгөөн заслын туслах үйлчилгээ	Мэргэжлийн боловсрол (1 жил)	2027.07.01
8	Хэнтий аймгийн Бор-Өндөр суман дахь мэргэжлийн боловсролын сургууль	02.Урлаг, хүмүүнлэг	021105	Хэвлэлийн график дизайн	Мэргэжлийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071310	Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт	Мэргэжлийн боловсрол	2027.07.01

9	Сэргээн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв	10.Үйлчилгээ	101102	Ажлын байр, барилга байгууламж, цэвэрлэгээ үйлчилгээ	Мэргэжлийн боловсрол	2027.07.01
10	Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Булган аймаг дахь Политехник коллеж	07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071401	Электроникийн тоног төхөөрөмж ашиглалт, засвар	Техникийн боловсрол	2027.07.01
		08.Хөдөө аж ахуй, загасны аж ахуй, мал эмнэл зүй	084101	Мал, амьтны эмнэл зүй	Техникийн боловсрол	2027.07.01
		08.Хөдөө аж ахуй, загасны аж ахуй, мал эмнэл зүй	081102	Мал зүй	Техникийн боловсрол	2027.07.01
		08.Хөдөө аж ахуй, загасны аж ахуй, мал эмнэл зүй	082101	Ойн аж ахуй	Техникийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071601-2	Хөдөө аж ахуйн машин, механизмын засвар, үйлчилгээ	Техникийн боловсрол	2027.07.01
11	Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн харьяа политехник коллеж	07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071310	Цахилгаан хангамж, тоног төхөөрөмжийн ашиглалт	Техникийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	078807	Үйлдвэрийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ	Техникийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	072405	Өрөмдлөгийн машин, тоног төхөөрөмж ашиглалт	Техникийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	072902	Уурхайн машин механизмын ашиглалт	Техникийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071601	Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	Техникийн боловсрол	2027.07.01
12	Дархан-Уул аймаг дахь Дархан политехник коллеж	07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071502-1	Металлурги, металлын технологи	Мэргэжлийн боловсрол	2027.07.01
13	Хөдөө аж ахуйн их сургуулийн харьяа Сэлэнгэ аймаг дахь Политехник коллеж	07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071601-2	Хөдөө аж ахуйн машин, механизмын засвар, үйлчилгээ	Техникийн боловсрол	2027.07.01
		06.Мэдээлэл, харилцаа холбооны технологиуд	061303	Мэдээллийн систем	Техникийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071601	Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	Техникийн боловсрол	2027.07.01
14	Өмнөговь аймгийн политехник коллеж	07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	072409	Эрдэс, чулуулаг боловсруулах төхөөрөмжийн ашиглалт	Мэргэжлийн боловсрол	2027.07.01

15	Орхон аймаг дахь Политехник коллеж	07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071601	Тээврийн хэрэгслийн засвар, үйлчилгээ	Техникийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	071309-1	Цахилгаан хэрэгслийн засвар үйлчилгээ	Техникийн боловсрол	2027.07.01
		07.Инженерчлэл, үйлдвэрлэл, барилга байгууламж	072105	Хоол үйлдвэрлэл	Техникийн боловсрол	2027.07.01

---o0o---